I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,263,173.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,263,173.2
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,029.3
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,027,648.2
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	178,367.7
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37,128.0

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг дарга Ж.Жавхаатөгс танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн авлагын данстай холбоотой зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 3 дугаар сарын 05-аас 2022 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Засаг даргад хүргүүлэхээр төлөвлөн, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Мөнхбамбар гүйцэтгэв.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газарт 2022 он 03 дугаар сарын 10-ны өдрийн 1/98 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Орон нутгийн онцлогт нийцсэн олон тулгуурт эдийн засгийг хөгжүүлж, цахимд суурилсан төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ” гэж тодорхойлсон байна.

3.3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх зэрэг үр дагавартай байна.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 17,837.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 178.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 124.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 598.4 сая, эцсийн үлдэгдэл 759.8 сая төгрөг болж, 537.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<i>Касст байгаа бэлэн мөнгө</i>	-	-	-	-
<i>Банканд байгаа бэлэн мөнгө</i>	10.6	0.03	-10.6	0.0
<i>Төрийн сангийн харилцах</i>	749.2	837.3	88.1	100.0
Дүн	759.8	837.3	77.5	100.0

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 837.3 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 0.03 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийн 237.7 сая төгрөг буюу 28.4 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого, 62.3 сая төгрөг буюу 7.4 хувийг ОНХС-ийн төсөл арга хэмжээний санхүүжилт, 12.6 сая төгрөг буюу 1.5 хувь байгууллагуудын жилийн эцсийн харилцахын үлдэгдлийг нэгдсэн дансанд төвлөрүүлсэн, төлөвлөснөөс давсан татварын болон татварын орлого 524.6 сая төгрөг буюу 62.7 хувийг тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Барилгын материалын худалдан авахдаа 0.9 сая төгрөг илүү шилжүүлсэн учир төлбөрийн акт тогтоов. /Уртын гэгээ ОНӨААТҮГ/
- Цалингийн урьдчилгааг сард олговол зохих хэмжээнээс хэтрүүлэн 4.5 сая төгрөгөөр олгож, 1.9 сая төгрөг суутгаагүй авлагаар илэрхийлж, төсвийн үлдэгдлийг төвлөрүүлээгүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон. /Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургууль/
- Цалингийн сангаас 2 дугаар байрны дээврийн засварт 3.1 сая төгрөг, багш ажилчдын эрүүл мэндийг дэмжихэд “fohow” аппаратаар үйлчилгээ үзүүлэх 4.1 сая төгрөг нийт 7.2 сая төгрөгийн гэрээ байгуулж, төсвийг зориулалт бус зарцуулсан бөгөөд хийгдээгүй ажилд хөрөнгө шилжүүлж, төсвийн үлдэгдлийг төвлөрүүлээгүйд төлбөрийн акт тогтоов. /Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургууль/
- Сургалтын удирдлагын “moodle sols” системийг сургалт хийх зардлын хамт 5.0 сая төгрөгөөр “ICT” компанитай гэрээ байгуулж худалдан авсан. Гэтэл Боловсролын газрын мэргэжилтэнтэй тус программыг нэвтрүүлэхтэй холбоотой цалингийн сангаас сургалтын зардалд 2.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, төсвийг зориулалт бус зарцуулсан тул төлбөрийн акт тогтоов. /Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургууль/

- Сургалтын менежер томилолтоор ажилласан газраар албан томилолтын хуудсыг хаалгаагүй, баримт нь нотлогдоогүй байхад 0.2 сая төгрөгийг олгосонд төлбөрийн акт тогтоосон. /Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лабортари нэгдүгээр сургууль/
- Хичээл, үйлдвэрлэл, хоолны хүнсний зардлаас 14.2 сая төгрөгийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй зөрчилд албан шаардлага өгсөн. /Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лабортари нэгдүгээр сургууль/
- Хүчин төгөлдөр бус гэрээг орчлон сургуулийн багштай байгуулж 5 сурагчид давтлагын хөлс 0.9, багш нарын сургалтад 1.3, мөн бичиг хэргийн ажилтныг чадваржуулах хөлс 0.6 сая төгрөг нийт 2.8 сая төгрөгийг цалингийн сангаас олгож, төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. /Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лабортари нэгдүгээр сургууль/
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин сургалт, семинар, нормын хувцас, уралдаан тэмцээн зохион байгуулахад зориулж төсвийн хөрөнгийг үр ашиггүй үрэлгэн зарцуулсан, тавилга эд хогшил бэлтгэсэн, шинээр ажлын байр нэмэгдүүлсэн зэрэг 57.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. /Баруун-Урт сумын ЗДТГ, Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын 1, 3, 4-р сургууль, Баруун-Урт сумын 1, 4, 6, дугаар цэцэрлэг, боловсрол өргөө дотуур байр/

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 1,132.5, эцсийн үлдэгдэл 892.5 сая төгрөг болж, 240.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	39.7	23.0	-16.7
Зээлийн хүүгийн авлага	25.1	21.4	-3.7
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	12.2	24.9	12.7
Байгууллагаас авах авлага	140.7	8.9	-131.8
Хувь хүмүүсээс авах авлага	674.8	1,069.8	395.0
Дүн	892.5	1,148.0	255.5

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 831.4 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн 21.3 сая төгрөгийн,
- Сум хөгжүүлэх сангийн үндсэн зээлийн 794.7 сая төгрөгийн,
- Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2.7 сая төгрөгийн,
- Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газрын 1.2 сая төгрөгийн,
- Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газрын 11.5 сая төгрөгийн авлага байна.

Эдгээр нь найдваргүй авлага үүсэх үр дагавартай байгаа учир менежментийн захидалд авах арга хэмжээний талаар зөвлөмж хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт:

- Тайлант оны төсөвт үлдэж төвлөрүүлэх хөрөнгийг харилцагч байгууллагад шилжүүлж, бодит бус авлага үүсгэсэн 7.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов. /Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын 2-р сургууль, Баруун-Урт сумын 3-р цэцэрлэг/
- Худалдан авалтын НӨАТ-ын буцаан авалтын 24.9 сая төгрөгийн авлагыг аймгийн Тамварын хэлтэстэй тооцоо нийлээгүй данс бүртгэлд тусгасан зөрчилт албан шаардлага хүргүүлсэн. /Уртын гэгээ ОНӨААТҮГ/

3.5.3 УРЬДЧИЛГАА

Урьдчилгаа дансны үлдэгдэл эцсийн үлдэгдэл 24.9 сая төгрөг болж өссөн байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0.0	24.9	24.9
Дүн	0.0	24.9	24.9

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Уртын гэгээ ОНӨААТҮГ гудамж талбайн гэрэлтүүлгийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор БНХАУ-ын Эрээн хотоос материал татахаар 24.9 сая төгрөгийг харилцагч байгууллагын дансанд шилжүүлсэн боловч Ковид цар тахлын улмаас хил хаагдаж, тухайн материалыг тайлант онд хүлээн авах боломжгүй болсноос үүссэн байна.

3.5.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 1,175.2 сая, эцсийн үлдэгдэл 1,380.0 сая төгрөг болж, 204.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Эм боох материал	16.9	10.1	-6.8
Түрээсийн сурах бичиг	61.8	61.8	0.0
Дуусаагүй үйлдвэрлэл	449.5	207.4	-242.1
Бичиг хэргийн материал	20.4	15.8	-4.6
Аж ахуйн материал	41.7	54.3	12.6
Сэлбэг хэрэгсэл	8.4	0.7	-7.7
Түлш тослох материал	0.4	-	-0.4
Барилгын засварын материал	17.9	6.6	-11.3
Хүнсний материал	40.5	11.4	-29.1
Бусад хангамжийн материал	711.1	819.5	108.4
Мал амьтад	11.7	14.6	2.9
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	-	51.3	51.3
Дүн	1,380.3	1,253.5	-178.1

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон, ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 207.4 сая төгрөгийн хөрөнгийг захиалагч байгууллага дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэсэн байна.

Бараа материалын үлдэгдэл 1,253.5 сая төгрөг болж 178.1 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд короновирус өвчлөл нэмэгдсэнтэй холбогдуулан улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин, сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа зогсоосонтой холбогдуулан хүнсний материалын үлдэгдэл буурсан, мөн төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлсэнтэй холбогдуулан үр ашиггүй зардал бага гарч өмнөх онуудад нөөцөлсөн материалыг зарцуулсан зэрэг нь үлдэгдэл буурахад нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Хоолны зардлаас хэмнэгдсэн хөрөнгө нь төсвийн хэмнэлтэд тооцогдоогүй бөгөөд төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлэлгүй, 5.1 сая төгрөгийн хүнсний материал нөөцөлд төлбөрийн акт тогтоов. /Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лабортари нэгдүгээр сургууль, Баруун-Урт сумын 9, 11 дүгээр цэцэрлэг/

- Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас худалдан авсан бараа, ажил үйлчилгээг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21-т заасан хэрэглэгчийн системтэй этгээдээс худалдан авалт хийсэн боловч төлбөрийн баримтыг хавсраагүй, өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй тул албан шаардлага хүргүүлсэн. /Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лабортари нэгдүгээр сургууль/
- Тээвэр шатахууны зарцуулалтад замын хуудсыг бүрэн, тодорхой, иж бүрэн хөтлөөгүй, дотоод хяналт сул, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулагдсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. /Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лабортари нэгдүгээр сургууль/

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 19,111.1 сая, эцсийн үлдэгдэл 21,814.8 сая төгрөг болж, 2,703.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	15,365.2	16,448.6	1,083.4
Авто тээврийн хэрэгсэл	325.7	470.4	144.7
Машин тоног төхөөрөмж	1,749.0	1,605.6	-143.4
Тавилга эд хогшил	1,353.0	1,430.1	77.1
Зам, гүүрийн байгууламж	13.0	174.8	161.8
Номын фонд	267.5	240.5	-27.0
Бусад үндсэн хөрөнгө	1,445.7	3,193.3	1,747.6
Программ хангамж	10.4	11.3	0.9
Бусад биет бус хөрөнгө	1,289.2	1,289.2	0.0
Дүн	21,818.7	24,863.8	3,045.1

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 24,863.8 сая төгрөг болж 3,045.1 сая төгрөгөөр өссөн байна. Уртын гэгээ ОНӨААТҮГ-т чулууны үйлдвэрийн хөрөнгө, Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газрын бусад үндсэн хөрөнгөд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгүүдийг бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг бодитой, үнэн зөв тооллого хийгээгүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. /Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лабортари нэгдүгээр сургууль/
- Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. /харьяа бүх байгууллага/
- Үндсэн хөрөнгө худалдан авахдаа хэрэгцээ шаардлагыг - бодитой тодорхойлсон эсэх нь тодорхойгүй, өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр болон ИТХ, орон нутгийн өмчийн албаны зөвшөөрөлгүйгээр хөрөнгө худалдан авсан. /Баруун-Урт сумын ЗДТГ, Баруун-Урт сумын 9, 10 дугаар цэцэрлэг/

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 356.6 сая, эцсийн үлдэгдэл 330.5 сая төгрөг болж, 26.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх
----------	----------------	-----------------	------------------	------------

				хувь
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	330.5	74.3	-256.2	2.3
<i>Ажилчидтай холбогдсон өглөг</i>	7.0	4.2	-2.8	0.1
<i>Бараа үйлчилгээний зардлын өглөг</i>	14.5	0.0	-14.5	0.0
<i>Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг</i>	2.1	0.0	-2.1	0.0
<i>Байгууллага төлөх өглөг</i>	261.1	60.0	-201.1	1.8
<i>Хувь хүмүүст төлөх өглөг</i>	45.8	10.1	-35.7	0.3
<i>Бусад урьдчилж орсон орлого</i>	2,058.4	3,216.8	1,158.4	97.7
Нийт дүн	2,388.9	3,291.1	902.2	100.0

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр 3,291.1 сая төгрөг болж 902.2 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь Уртын гэгээ ОНӨААТҮГ-т үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг урьдчилж орсон орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь өр төлбөр өсөхөд нөлөөлсөн байна. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 4.2 сая төгрөгийн ажилчидтай холбогдсон өглөг, 60.0 сая төгрөгийг байгууллагад төлөх өглөг, 10.1 сая төгрөгийн хувь хүмүүст төлөх өглөг, 3,216.8 сая төгрөгийн урьдчилж орсон орлогын байна.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 17,330.1 сая, эцсийн үлдэгдэл 19,064.9 сая төгрөг болж, 1,734.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
<i>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</i>	6,680.7	6,680.7	0.0	35.0
<i>Хуримтлагдсан үр дүн</i>	7,675.3	9,410.1	1,734.8	49.4
<i>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</i>	2,974.1	2,974.1	0.0	15.6
Дүн	17,330.1	19,064.9	1,734.8	100.0

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 19,064.9 сая төгрөг болж 1,734.8 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь өмнөх үеийн үр дүнд алдааны залруулга хийж 1.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, тайлант үед 1,733.2 сая төгрөгийн үр дүнтэй ажилласан нь нөлөөлсөн байна.

3.5.9 Орлогын данс

Татварын болон татварын бус орлого 1,979.7 сая, зээлийн хүүгийн орлого 16.9 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 2,264.3 сая, борлуулалтын орлого 522.9 сая, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 10,628.8 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих 558.8 сая, туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих 509.7 сая, нэмэлт санхүүжилтийн орлого 1,263.2 сая, орон нутгийн төсвөөс санхүүжих 2,979.3 сая, нийт 20,723.6 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

3.5.10 Зардлын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зарлага 17,855.6 сая төгрөг болж өмнөх оноос 625.9 сая төгрөг буюу 3.4 хувиар буурсан байна.

Тайлант онд цалин хөлс нэмэгдэл урамшлын зардалд 9,197.6, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 1,179.4, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,889.5, хангамж, бараа материалын зардал 261.2, норматив зардалд 381.8, эд хогшил,

урсгал засварын зардалд 197.7, томилолт зочны зардалд 14.8, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 3,164.2, бараа үйлчилгээний бусад зардалд 1,202.3, урсгал шилжүүлэгт 367.1, үйл ажиллагааны бус зардалд 1,134.8 сая нийт 18,990.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн 7/03 дугаар тогтоолд зааснаар сумын төсвийн татварын орлого 1,227.9 сая төгрөг, татварын бус орлого 278.3 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 1,900.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 126 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт № 7 Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ОРЛОГО	1,506.3	1,900.4
ТАТВАРЫН ОРЛОГО	1,228.0	1,531.6
Хувь хүний орлогын албан татвар	865.0	1,191.2
Үйл ажиллагааны орлого	95.0	75.4
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	30.0	111.7
Хөрөнгийн орлого	440.0	499.5
Шууд бус орлого	300.0	504.6
Хөрөнгийн албан татвар	108.0	113.3
Бууны албан татвар	8.0	8.6
Малд ногдуулах албан татвар	100.0	104.7
Бусад татвар (төлбөр, хураамж)	205.0	174.1
Улсын тэмдэгтийн хураамж	95.0	88.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	110.0	85.6
Газрын төлбөр	50.0	53.0
Газрын төлбөр	50.0	53.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	278.3	368.8
Хүү, торгуулийн орлого	265.0	347.3
Бусад нэр заагдаагүй орлого	13.3	21.5

Орон нутгийн орлого 394.1 сая төгрөгөөр давсан нь тус суманд Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 81.7 сая, шууд бус орлого 204.6 сая, хөрөнгийн орлого 59.5 сая, хүү торгуулийн орлого 82.3 сая төгрөгөөр тус тус давж биелсэн нь нөлөөлсөн байна.

Төсвийн төсөвлөлт

Баруун-Урт сумын Засаг даргын 2021 онд татварын орлогыг 1,007.4 сая, татварын бус орлогыг 140.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Нийт зардлын 4,628.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 10,628.8 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 558.7 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 464.2 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс, 200.0 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангийн

зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогоос, 400.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 10,594.9 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 558.8 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 4,479.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 265.5 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогоос, 293.8 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос нийт 16,192.0 сая төгрөгийн санхүүжилт авч, тусгай зориулалтын шилжүүлгээс 33.8 сая төгрөг, орон нутгийн санхүүгийн дэмжлэг 149.7 сая төгрөгөөр тус тус дутуу санхүүжигдэж, туслах үйл ажиллагааны орлогоос 106.2 сая төгрөг тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 16,356.1 сая төгрөг буюу 97 хувьтай байгаа нь харилцах дансны үлдэгдэл төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсөв: Төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс авсан хандив тусламжаар 20.0, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1,027.6, дээд шатны төсвийн захирагчаас 178.4, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 37.1, нийт 1,263.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал 0.6, хангамж, бараа материалын зардалд 36.0, нормативд зардалд 3.4, эд хогшил, урсгал засварын зардалд 25.3, томилолт, зочны зардалд 1.2, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,151.3, бараа үйлчилгээний бусад зардалд 24.9, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 7.7 сая төгрөг нийт 1,250.4 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 12.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 165 мэдээллээс хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаандаа оруулсан 137, хугацаа хоцроосон 25 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа боловч зарим мэдээллийг хангалтгүй байршуулсан гэж дүгнэлээ.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Нийт 4 зөвлөмж өгснөөс 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.
Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	-	3	-	-	-	75.0
Нийт дүн	4	-	3	-	-	-	75.0

3.9. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Баруун-Урт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 18 төсвийн байгууллага, 1 ОНӨААТҮГ, 2 тусгай сан нийт 21 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 14 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 11 байгууллагад “Зөрчилгүй”, 2 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” /Баруун-Урт сумын 3 дугаар цэцэрлэг, Уртын гэгээ ОНӨААТҮГ/, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Сөрөг” /Сүхбаатар аймгийн лаборатори 1 дүгээр сургууль/ дүгнэлт өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Баруун-Урт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд өмнөх оны алдааны залруулгыг тайлант оны зардалд илэрхийлсэн 1.3 сая, бараа материалыг үлдэгдэл 10.1 сая төгрөгөөр зөрүүтэй, 1.6 сая төгрөгөөр өр төлбөрийг илүү, 3.2 сая төгрөгийн өр төлбөр дутуу нэгтгэсэн
- Урьдчилж орсон орлогын тайлант жилийн элэгдлийн зардал 79.3 сая төгрөгийг орлого үр дүнгийн тайланд илэрхийлээгүй зэрэг алдаа зөрчлийг анхан шатны баримт, УСНББОУС, дүрэм журамд нийцүүлэн тус тус залруулж, данс бүртгэлд тусгуулав,

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3,086.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 95.5 сая төгрөгийн 9 алдаа зөрчлийг залруулж, 25.0 сая төгрөгийн зөрчилд 11 төлбөрийн акт тогтоож, 939.6 сая төгрөгийн 20 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал хүргүүлж, 2,025.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 50 зөвлөмжийг хүргүүллээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Авлага данстай холбоотой

4.1.1 Илрүүлэлт: Өмнөх онуудад үүссэн, эзэн холбогдогч нь тодорхойгүй авлагыг барагдуулах ажил удаашралтай, хангалтгүй байна.

4.1.2 Эрсдэл: Төсвийн хуулийг дагаж мөрдөхгүй байх, найдваргүй авлага үүсэх.

4.1.3 Өгсөн зөвлөмж: Өмнөх онуудад үүссэн эзэн холбогдогч нь тодорхойгүй авлагыг харилцагч байгууллагатай тулган баталгаажуулах бичиг илгээж бодиттой байгаа эсэхийг тогтоож, барагдуулах

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

4.2 Данс бүртгэлтэй холбоотой асуудал:

4.2.1 Илрүүлэлт: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд биологийн хөрөнгө болох мал амьтад болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг данс бүртгэлд бодит үнэ цэний аргаар толилуулаагүй нийтлэг алдаа гарсан байна.

4.2.2 Эрсдэл: НББ-ийн тухай хууль зөрчигдөх, Санхүүгийн нэгтгэсэн тайлан буруу илэрхийлэгдэх, Санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, оршин байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх

4.2.3 Өгсөн зөвлөмж: Байгууллагуудын бүртгэлийг сайжруулж, дараагийн тайлангийн нэгтгэлийг хийхдээ Сангийн сайдын 2016 оны 12 сарын 16-ны өдрийн “Стандарт батлах тухай” 411 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын дагуу биологийн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүртгэлийг иж бүрэн нэвтрүүлж, алдааг байгууллага бүр дээр залруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

4.3 Данс бүртгэлтэй холбоотой асуудал:

4.3.1 Илрүүлэлт: Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.3 /дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх/ заалттай нийцэхгүй байна.

4.3.2 Эрсдэл: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд дансанд хуримтлуулан бүртгээгүйн улмаас нягтлан бодох бүртгэлийн хяналтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.

4.3.3 Өгсөн зөвлөмж: Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгэх.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	78	2,116.2	3	1.8	10	24.1	14	75.5	35	2,014.7
2	Төсөл, хөтөлбөр	2	834.7	-	-	-	-	2	843.7	-	-
3	ОНӨААТҮГ	13	135.1	6	93.7	1	1.0	3	29.4	3	11.1
4	ТТЗ	4	-	-	-	-	-	1	-	3	-
	НИЙТ	97	3,086.0	9	95.5	11	25.1	20	948.6	41	2,025.8

5.2 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	18	13	5	-	11	1	1	-
2	Төсөл, хөтөлбөр	2	-	2	-	-	-	-	-
3	ОНӨААТҮГ	2	1	-	-	-	1	-	-
4	ТТЗ	1	1	-	-	-	1	-	-
	НИЙТ	23	15	7	-	11	3	1	-